

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

Баримт бичгийн мэдээлэл	
Баримт бичгийн дугаар:	ЖР-ТУЗ004 /ТУЗ-ийн хурлын 23/11/16-ны өдрийн 23/016 тоот тогтоолын Хавсралт 3/1.0
Баримт бичгийн хувилбарын дугаар:	2023/11/16
Хүчин төгөлдөр болсон огноо:	Нийтэд хүртээмжтэй
Мэдээллийн ангилал:	3
Мэдээллийн түвшин:	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга
Хариуцагч:	ТУЗ, Гүйцэтгэх захирал
Хэрэглэгч:	

	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг
Баталсан:	Г.Хатанболд	ТУЗ-ийн дарга	
Боловсруулсан:	Ч.Жаргал	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	

Өөрчлөлтийн түүх

Хувилбарын №	Огноо	Боловсруулсан	Өөрчлөлтийн тайлбар	Хянасан	Баталсан
1.0	2023/11/16	Ч.Жаргал	Анхны хувилбар	ТУЗ-ийн гишүүд	Г.Хатанболд

Түгээлт

Тайлбар

Айтүүлс ХК-ийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигч, олон нийтэд нээлттэй түгээгдэнэ. Энэхүү баримт бичгийг хувилбарын дугаараар хянана.

ГАРЧИГ

1. Нийтлэг үндэслэл.....	3
2. Үндсэн чиглэл	4
3. ТУЗ-ийн цалин, урамшуулал.....	4
4. Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал	5
5. Компанийн ажилтны цалин, урамшуулал.....	5
6. Бусад.....	5

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү баримт бичгээр компанийн цалин, урамшууллын зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.

2. Үндсэн чиглэл

- 2.1. Цалин, урамшууллын талаар компанийн хэмжээнд баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 2.1.1. ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох;
 - 2.1.2. цалин, урамшууллын хуваарилалтад аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлыг гаргахгүй байх;
 - 2.1.3. цалин, урамшууллыг ур чадвар болон ажлын үнэлгээ, үр дүнд суурилж тогтоох;
 - 2.1.4. хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон компанийн ашигт ажиллагаа, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, макро эдийн засгийн төлөв, инфляцийн түвшинтэй уялдуулж бодит цалингийн өсөлтийг хангахыг эрмэлзэх;
 - 2.1.5. зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшууллын тогтолцоогоор дамжуулан, мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг тогтвортой ажиллуулах;
 - 2.1.6. цалин урамшууллыг ажилтны мэдлэг, ур чадвар, ажлын байрны үнэ цэн, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилж олгох;
 - 2.1.7. ажилтнуудын ур чадвар, гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулж, ажлын байран дахь сэтгэл ханамжийг дээшлүүлэх;
 - 2.1.8. Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, Зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалын дагуу ажиллагсдын цалин, урамшууллыг шударга хуваарилах, ажиллагсдын эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр болон хамтын гэрээ байгуулах эрхийг хүлээн зөвшөөрөх.
- 2.2. ТУЗ-ийн дэргэдэх цалин, урамшууллын хороо /цаашид "Хороо" гэх/ нь компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудад олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, холбогдох хууль тогтоомж болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлын хүрээнд дараах хэлбэрээр, зохистой хэмжээг тогтооно. Үүнд:
 - 2.2.1. тогтмол цалин;
 - 2.2.2. хуралд оролцсон цалин;
 - 2.2.3. компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулалт цалин;
 - 2.2.4. мэргэжлийн, өндөр ур чадвартай гүйцэтгэх удирдлагыг тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхжүүлэхэд хангалттай хэмжээний цалин, урамшуулал;
 - 2.2.5. компанийн үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалсан бусад хэлбэрийн урамшуулал.

3. ТУЗ-ийн цалин, урамшуулал

- 3.1. ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин, урамшууллын талаар ТУЗ-д санал хүргүүлнэ.
- 3.2. ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин, урамшууллыг хуралд оролцсон байдлаар олгохоор тооцно. Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор компанийн ашигт ажиллагаа, макро эдийн засгийн төлөв байдлаас хамааран, тогтмол цалин, хурал даргалах цалин, ТУЗ-ийг удирдах цалин, хараат бус гишүүний нэмэгдэл хөлс, компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулал цалин, хороодын үйл ажиллагаанд оролцсон цалинг олгож болно.
- 3.3. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалинг ТУЗ тогтооно.
- 3.4. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг Компанийн жилийн тайланд тодорхой тусгана.

4. Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал

- 4.1. Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал нь үндсэн цалин болон урамшууллаас бүрдэнэ.
- 4.2. Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр тодорхойлно.
- 4.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд Гүйцэтгэх захирлын үндсэн цалин, шагнал, бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.
- 4.4. Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг Компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнгээр үнэлэх ба урамшуулал олгох, цалинг шинэчлэн тогтоох эсэхийг ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 4.5. Хувьцаа эзэмшигчдэд Гүйцэтгэх захиралд бодитоор олгосон цалин, урамшууллын дүнгийн мэдээллийг ил тод байлгана.

5. Компанийн ажилтны цалин, урамшуулал

- 5.1. Компанийн Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон нийт ажилтнуудын цалин, урамшууллыг Гүйцэтгэх захирал энэхүү бодлого, зарчимд нийцүүлж тогтооно.
- 5.2. Гүйцэтгэх захирал компанийн ажилтнуудын цалин хөлс, урамшууллыг жил бүр шинэчлэн тогтоож болох ба нийт цалингийн санг тухайн жилийн бизнес төлөвлөгөөнд тусган ТУЗ-өөр батлуулна.
- 5.3. Цалин урамшууллын хороо нь компанийн ажилтны цалин, урамшуулалтай холбоотой дотоод дүрэм, журам, тогтолцоог дүгнэж, энэхүү бодлого, холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт тавин, өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д тайлагнаж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлнэ.

6. Бусад

- 6.1. Энэхүү журам нь ТУЗ-ийн баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 6.2. Энэ бодлогын хэрэгжилтэд Цалин урамшууллын хороо хяналт тавьж ажиллана.
- 6.3. Шаардлагатай гэж үзвэл энэ бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг ТУЗ-өөс шийдвэрлэнэ.